

# Хүүхдүүдэд Чех улсын иргэншил олгох

Хүүхдүүд Чех улсын иргэншлийг хэд хэдэн аргаар авах боломжтой.

## Төрсний дараа

Хүүхэд төрөх үед эцэг эхийн нэг нь Чех улсын иргэн бол хүүхэд төрөхдөө Чех улсын иргэн болно - хаана төрсөн нь хамаарахгүй

Өргөдөл өгөх шаардлагагүй, Чех улсын иргэншил шууд олгогдоно (Чех улсын иргэн болохыг нотлох баримт бичиг бол жишээ нь: гадаад паспорт, иргэний үнэмлэх).

Хэрвээ хүүхэд гадаадад төрсөн - бол эхлээд иргэний бүртгэл мэдээллээс тусгай өргөдөл хүсэх хэрэгтэй ([Брнод байдаг тусгай иргэний бүртгэл мэдээллийг газар](#)), үүнээс үндэслэн хүүхдэд Чехийн төрсний гэрчилгээ олгоно (иргэний үнэмлэх эсвэл Чех улсын гадаад паспорт олгоход шаардлагатай).

Хэрвээ хүүхэд Чех улсад төрөөд иргэншилгүй бол шууд Чехийн иргэншэл авна, эцэг эх нь хоёулаа иргэншилгүй мөн эцэг эхийн нэг нь Чех улсад 90-ээс дээш хугацаагаар амьдрах эрхтэй болно.



**АНХААР!** Чех улсын хууль зүйн системд олон иргэншилтэй байх боломжийг олгодог.

Дэлгэрэнгүй мэдээллийг [эндээс](#).

## Эцэг тогтоох

Гэрлэлтээс гадуур төрсөн хүүхдийн ээж нь Чех улсын иргэн биш (жишээ нь: иргэншилгүй) харин аав нь Чех улсын иргэн бол.

- Эцэг эхийн хоёулангаас эцэг тогтоох зөвшөөрсөн мэдэгдэл – хэрвээ ээж нь ЕХ-ны өөр гишүүн орны иргэн, эсвэл байнга оршин суух эрхтэй, эсвэл гэр оронгүй бол.
- Эцэг эхийн хоёулангаас эцэг тогтоох зөвшөөрсөн мэдэгдэл – хэрвээ ээж нь ЕХ-ны өөр гишүүн орны иргэн биш, эсвэл байнга оршин суух эрхгүй, эсвэл гэр оронгүй бол иргэний бүртгэл мэдээллээс генетикийн эцэг эх тогтоох шинжилгээ хийнэ.

Гадаадад төрсөн хүүхдийн хувьд эхлээд Брнод байрлах тусгай иргэний бүртгэл мэдээллийн төвөөс бүртгүүлэх өргөдөл гаргуулах шаардлагатай.

**АНХААР!** Энэхүү иргэншил олгох нь шууд бус бөгөөд заавал нотлох ёстой. Иргэншлийг эцгийн өгсөн мэдэгдэл гарах үед шийдэгдэнэ – эцэг нь хүүхэд төрөх үед бус харин эцэг тогтоосноор шийдэгдэнэ.



## Үрчлэх (дараах тохиолдолд боломжтой):

- Хэрэв үрчлэхийг нь Чех улсын байгууллагын шийдвэрээр гарсан бол – үрчлэгчийн нэг нь Чех улсын иргэн байх.
- Хэрэв үрчлэхийг гадаадыг байгууллагын шийдвэрээр гаргасан бол – Чехийн хууль эрх зүйн дагуу хүлээн зөвшөөрсөн шийдвэр гарсны дараа хүүхэд иргэншилтэй болно.

## Хүсэлтийн дагуу иргэншил олгох – 15-аас доош насны хүүхдүүд

- Төрсний гэрчилгээ – шаардлагатай бол Чех хэл дээрх орчуулсан ба дээд шатны баталгаажуулалттай хуулбар байх (апостиль, хэт хуульчлах)
- Намтар
- Гадаад паспорт болон байнга оршин суух картын хуулбар
- Хөдөлмөр олголтын газраас улсын нийгмийн хангамж болон дэмжлэг тусламжийг төлсөн тэтгэмжийн мэдээлэл, эсвэл өргөдөл гаргагч тэтгэмж авч байгаагүй талаарх тодорхойлолт
- Өргөдөл гаргагч нь ажил хайгчдын бүртгэлд бүртгэгдсэн байсан (байгаагүй) гэсэн тодорхойлолт
- Иргэншил олгохыг зөвшөөрсөн эцэг эхийн зөвшөөрөл
- Орон байрны баталгаа (түрээсийн гэрээ, кадастрын хуулбар)
- Сургуулийн тодорхойлолт (цэцэрлэг, бага сургуулийн) мөн сургуулийн сүүлийн жилийн дүнгийн тайлан
- Чех улсад мөн гадаадад 5-аас доошгүй жил оршин суусан гэсэн бичиг баримт, тодорхойлолт
- Сүүлийг 3 жилийг бичиг баримт
  - o Эцэг эх нь ажил эрхлээгүй тохиолдолд – насанд хүрээгүй өргөдөл гаргагчийн үндсэн хэрэгцээг хангахад ашигладаг санхүүгийн эх үүсвэр (жишээлбэл: тахир дутуугийн болон өндөр насны тэтгэвэр, гадаадаас ирсэн орлого, Хөдөлмөр олгох газраас тэтгэмж авдаг гэсэн тодорхойлолт).
  - o Эцэг эх нь ажил эрхэлдэг бол – ажлын гэрээ болон цалингийн тодорхойлолт эсвэл татварын тайлангийн хуулбар
- Өргүй г нотлох баримт, тодорхойлолт
  - o VZP тодорхойлолт (эсвэл өргөдөл гаргагчийн бүртгэлтэй даатгалын газраас)
  - o ČSSZ тодорхойлолт (нийгмийн даатгал)
- Өргүй г нотлох баримт, тодорхойлолт (30 хоногоос хэтрэхгүй байх ёстой):
  - o Татварын албанаас авсан тодорхойлолт
  - o Гаалийг байгууллагаас авсан тодорхойлолт
- VZP-ээс (эсвэл өргөдөл гаргагчийн бүртгэлтэй даатгалын газраас) бүртгэлийн мэдээлэл, шимтгэл болон төлбөрийг тооцооны баримт

**ЗӨВЛӨМЖ:** Энэ аргыг бид танд зөвлөхгүй байна. Хэрвээ та энэ аргаар иргэншлийн өргөдөл гаргах бол насанд хүрсэн гэр бүрийг нэг гишүүн өргөдөл хамт хүсэх нь илүү дээр.



## 18 настайдаа (хоёр дахь үеийн гадаадын иргэд гэгддэг) Чехийн иргэншил авах боломжтой.

- Үүнд: төрсний гэрчилгээ, гэрлэлтийн баталгаа (хамтран амьдраж буй баримт бичиг, гэрлэлт цуцлагдсан эсвэл хамтран амьдрах цуцлагдсан тухай баримт бичиг), эмнэлгийн бичиг, тогтоосон мэдүүлгийн маягт.



Дэлгэрэнгүй мэдээллийг [эндээс](#).



Spolufinancováno  
Evropskou unií



MINISTERSTVO VNITRA  
ČESKÉ REPUBLIKY



Poradna  
pro integraci

Projekt "Centrum na podporu  
integrace cizinců v Ústeckém kraji" reg.  
č. CZ.12.01.02/00/23\_008/0000008 je  
financován OP AMIF a MV ČR.